

*Харилцаа холбооны зохицуулах хорооны
2015 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн
63 тоот тогтоолын
хавсралт*

*Харилцаа холбооны зохицуулах хорооны
2015 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн
63 тоот тогтоолын
хавсралт*

**“Харилцаа холбооны салбарын үйлчилгээний тарифыг хянах журам”-д
оруулсан нэмэлт, өөрчлөлт**

Монгол Улсын Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.5, 9.1.6, 9.1.7, 9.1.12 болон Өрсөлдөөний тухай хуулийн 6.3-т заасан заалтуудыг үндэслэн тус хорооны 2015 оны 10 сарын 23-ны өдрийн 57 тоот тогтоолоор баталсан “Харилцаа холбооны үйлчилгээний тарифыг хянах журам”-д дараах нэмэлт өөрчлөлтийг оруулсан. Үүнд:

1. Журмын 3.7-д “Зохицуулах хороо нь үйлчилгээ эрхлэгчийн ирүүлсэн мэдээллийн нууцлалыг хамгаалах үүрэг хүлээнэ.”-гэсэн заалтыг шинээр нэмэх;
2. Журмын 6.1.-т “Зохицуулах хорооны хянасан үйлчилгээний тарифыг хэрэгжиж эхлэхээс 15 хоногийн өмнө нийтэд сурталчлах ажлыг үйлчилгээ эрхлэгч нар зохион байгуулна.” шинээр;
3. Журмын 6.2.-т “Шийдвэрийн хэрэгжилтэнд зохицуулах хорооны зүгээс хяналт тавьж ажиллана.” шинээр;
4. Журмын 3.3.-т Зүй ёсны монополь болон давамгай байдалтай аж ахуй эрхлэгчийн үйлчилгээний тарифын үндэслэлийг хянаж гаргасан санал дүгнэлт болон шаардлагатай гэж үзвэл маргаантай асуудлуудтай холбогдсон тарифын үндэслэлийг хянаж гаргасан санал дүгнэлтийг холбогдох албанаас хорооны хуралдаанд оруулж хэлэлцүүлэн, хорооны хуралдаанаас гарсан шийдвэрийг үйлчилгээ эрхлэгч нарт хүргүүлнэ.” гэсэн заалт дээр олон нийтэд нээлттэй мэдээлнэ гэж нэмж оруулан өөрчлөх;
5. Журмын 3.5 болон 6.1 заалтуудын ажлын гэдэг үгийг хасч өөрчлөх;
6. Журмын 4.1.4. –т байсан “Давамгай байдалтай үйлчилгээ эрхлэгчээр бүх нийтийн үйлчилгээний үүргийг хангуулах, зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцлийг бүрдүүлэх үүднээс тарифт шингээсэн ашгийн хувь хэмжээг тогтоох;” заалтыг хасах;

-----oOo-----